

АЖЛЫН ДААЛГАВАР

Байгууллагын нэр	Эрүүл мэндийн хөгжлийн төв
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын чадамжийн үнэлгээ
Гэрээний төрөл	Хувь зөвлөх үйлчилгээ – Дотоодын зөвлөх
Хэл:	Монгол
Гэрээний хугацаа:	2 сар

ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц”-д нийгмийн эрүүл мэндийн тандалт, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эх, хүүхэд, нярайн тусламж, дархлаажуулалт, сэтгэлзүйн тусламж, мэс заслын болон яаралтай тусламжийн үйлчилгээнүүд багтсан байдаг. Гэсэн хэдий ч Монгол Улс Нийгмийн эрүүл мэндийн ноцтой нөхцөл байдал үүсэх үед эдгээр үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, үүнд эмзэг бүлгийн хүн амыг хамруулах тодорхой төлөвлөгөө, удирдамж, заавар бүрэн боловсруулагдаагүй хэвээр байна.

Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын үеийн туршлагаас харахад эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, орны хүрэлцээ, хүчилтөрөгчийн тогтвортой хангамж, тоног төхөөрөмж, эм хангалт, эрүүл мэндийн ажилтнуудын хүрэлцээ, дэмжих дэд бүтэц хангалтгүй байсан нь зайлшгүй тусламж үйлчилгээний хязгаарлалтад хүргэж, олон эмгэгийн илрүүлэлт, хяналт, эмчилгээ доголдоход нөлөөлсөн.

Иймд, эмнэлгийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой эсэх чадамжийн үнэлгээг хийж, зөвлөмж, тайлан гаргаж, бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах ажлыг Глобал сангийн санхүүжилтээр Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулж байна.

ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Дотоодын зөвлөх дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааг хангах чадамжийн үнэлгээний аргачлалыг боловсруулна. Үүнд дараах чиглэлээр үзүүлэлтүүдийг тооцно:

- Дэд бүтцийн бэлэн байдал: барилга, ор, тоног төхөөрөмж,
- Хүний нөөцийн бэлэн байдал: хүрэлцээ, ур чадвар, сургалтад хамрагдсан байдал,
- Нөөцийн бэлэн байдал: эм, эмнэлгийн хэрэгсэл, ханган нийлүүлэлт, худалдан авалт,
- Зохион байгуулалтын бэлэн байдал: төлөвлөгөө, протокол, холбоо харилцаа.

2. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлын шалгуур тодорхойлно. Үүнд:

- Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал
- Чанар, аюулгүй байдал

- Хэрэгцээг хангах төлөвлөгөө
- Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ

3. Эрүүл мэндийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааг хангах чадамж, эрсдэлт хүчин зүйлс, нөөц, дэд бүтэц, зохицуулалтыг харьцуулж, үнэлнэ.

4. Нэн шаардлагатай тусламж үйлчилгээний тасралтгүй байдалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, чадавхжуулах чиглэлийг тодорхойлно.

5. Үнэлгээний үр дүнгийн дагуу нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зөвлөмж, төлөвлөгөөг боловсруулна.

ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БҮТЭЭГДЭХҮҮН:

Зөвлөх нь доор дурдсан бүтээгдэхүүнийг 2026 оны 03 сарын 30-ны дотор ирүүлнэ. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг үнэлэх аргачлалыг боловсруулж ЭМХТ-өөр хэлэлцүүлж, батлуулсан тайлан,
2. Эмнэлгийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой эсэх чадамжийн үнэлгээний тайлан,
3. Эмнэлгийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах боломжтой эсэх чадамжийн үнэлгээний зөвлөмж, бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулсан тайлан.

ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:

Гэрээний хугацаа нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний хооронд (ажлын 60 хоног) байна.

ЯВЦЫН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД:

Зөвлөх эцсийн бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацааг тусгасан ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулж гэрээнд хавсаргана. ЭМХТ-ийн Их өгөгдөл судалгааны албаны дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй байнга холбоотой ажиллана. Мөн Их өгөгдөл судалгааны албаны дарга, холбогдох мэргэжилтнүүд нь зөвлөхийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавина.

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

1. Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
2. Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
3. Гүйцэтгэсэн ажлын чанар.
4. Зөвлөх нь ЭМХТ-ийн Их өгөгдөл судалгааны албанд ажлын гүйцэтгэлийг тайлагнана.

Энэ ажлын даалгаварт заасан аль нэгэн бүтээгдэхүүнийг үндэслэлтэй нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болохоос өмнө нийлүүлж амжаагүй бөгөөд үүнээс шалтгаалж

гэрээний хугацааг сунгах тохиолдолд зөвлөх нэмэлт зардалгүйгээр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ:

Зөвлөх нь тохиролцсон бүтээгдэхүүнийг ЭМХТ-ийн Их өгөгдөл судалгааны албанд бүрэн хүлээлгэн өгсний дараа төлбөрийг бүрэн дүнгээр төлнө.

ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА:

Зөвлөхөд тавигдах шаардлага:

- Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн удирдлага болон бусад холбогдох чиглэлээр магистр эсвэл докторын зэрэг
- Эрүүл мэндийн байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс тасаг, нэгжийн эрхлэгч болон түүнээс дээш удирдах албан тушаал эрхэлсэн ба эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, нийгмийн эрүүл мэнд чиглэлээр 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Төсөл, хөтөлбөрт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Шаардагдах баримт бичгүүд:

1. Анкет (товч намтар) монгол хэл дээр;
2. Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбарууд;
3. Ажиллах хүсэлт (өргөдөл) бичгээр монгол хэл дээр;
4. Танай чадварыг батлахад туслах нэмэлт баримт бичгүүд.